



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 8/521

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 11-ний 06:00 цаг хүртэл шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгаас орох, гарах, сумаас сум хоорондох, багаас багийн хооронд эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, мал мах бэлтгэх, шатахуун, нүүрс түлээ, өвс, хивэг тэжээлийн тээврээс бусад бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоосугай.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталж, бусад бүх төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэр үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011101189

Аймгийн Засаг даргын 2020 оны.....
дүгээр сарынны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----|---|
| 1. | Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа /тооны хязгаартай/ |
| 2. | Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа |
| 3. | Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 4. | Шатахуун, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 5. | Төв, суурин газрын дулаан, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа |
| 6. | Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, хангандийн нийлүүлэлтийн үйл ажиллагаа |
| 7. | Банкны төлбөр тооцооны үйл ажиллагаа |
| 8. | Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, илгээмжийн үйл ажиллагаа |
| 9. | Тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа |
| 10. | Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын үйл ажиллагаа |
| 11. | Оршуулгын үйл ажиллагаа |
| 12. | Сав, баглаа боодол, хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаа |
| 13. | Модон эдлэл, барилгын хийц, материалын үйлдвэрийн үйл ажиллагаа |
| 14. | Бараа материалын цахим худалдаа, хүргэлтийн үйл ажиллагаа |
| 15. | Малын өвс, тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 16. | Арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа |
| 17. | Улсын онц чухал болон стратекийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа |
| 18. | Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа |

-оОо-